



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 01 өдөр

Дугаар 5-02

Мөрөн

Ажилд томилж, ажлаас чөлөөлөх тухай

Монгол улсын "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 35 дугаар зүйлийн 35.1.4, "Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол зэргийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүүхэд асрах чөлөөтэй байсан Эрдэнэчимэгийн Далайг хүсэлтийн дагуу 2019 оны 01 дүгээр сарын 1-нээс "Рэнчинлхүмбэ" цаг уурын өртөөний техникчээр эргүүлэн томилсугай.

2. "Рэнчинлхүмбэ" цаг уурын өртөөний техникчээр хүүхэд асрах чөлөөтэй ажилтаныг ажилдаа эргэн орох хүртэл хугацаанд ажиллаж байсан О.Отгонцэцэгийн хөдөлмөрийн гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 1-ны өдрөөр дуусгавар болгосугай.

3. Э.Далайгийн үндсэн цалинг Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээний ТҮ-6-2 дахь шатлалын дагуу 540846 /таван зуун дөчин мянга найман зуун дөчин зургаа/ төгрөгөөр тогтоосугай.

4. О.Отгонцэцэгтэй холбогдох тооцоог хийж дуусгахыг ня-бо Н.Эрдэнэцэцэгт үүрэг болгосугай.

5. Э.Далайгийн ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийн биелэлтэнд заавар зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллахыг "Рэнчинлхүмбэ" цаг уурын өртөөний дарга М.Долгорсүрэн, Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга Б.Өнөрбат нарт тус тус үүрэг болгосугай.



Г.АДЬЯАСҮРЭН